

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 оны 06 дугаар сарын мэдээлэл

2022.06.23.

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

-Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит VIII хуралдаанаар

1. Төсвийн тодотголыг хэлэлцэн баталсан. Үүнд:

а/. **Шинээр:** Аялал жуулчлалын цогцолбор бүхий “ОТОГ” байгуулахад 15 сая төгрөгийг төсөвлөв. **Санхүүжилтэд нь өөрчлөлт оруулсан нь:** ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх “Хашлага хамгаалалт”-ын 54 сая төгрөгийн ажлыг цуцалсан. “Залуус төв” барихад 52 сая төгрөг төсөвлөсөн байсныг 45,800000 төгрөг болгосон. “Баянголын гүүр”-засварлалтад 2 сая төгрөг нэмсэн, 2 дугаар багийн төвийн тохижилтын санхүүжилтийг 34 сая төгрөгөөр нэмж өгсөн. “Малчдын зөвлөгөөн” зохион байгуулахад нэмэлтээр 3 сая төгрөг нэмж өгсөн зэрэг тодотгол хийгдсэн байна.

2. 2022 оны Сумын Хөгжлийн төлөвлөгөөг батлав.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр хураамжийн асуудлыг хэлэлцэхээ хойшлуулсан.

3. Ундны усны үнэ бууруулж тогтоох асуудлыг хэлэлцэж холбогдох баримт бичгээ Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

-“ЗӨВ ХАНДЛАГА-ЭЕРЭГ НӨЛӨӨ” аяныг 2022.05.03-2022.06.16 ны хооронд зохион байгуулж тайланг хүлээн авсан. Үүнд: 6 байгууллагаас 4 байгууллага хугацаандаа тайлангаа ирүүлсэн. Аяны үр дүнд: а/. ЗДТГ-ын “Төрийн албан хаагчдын зөрчлийн талон” , б/. Хүүхдийн Цэцэрлэгийн “Инээмсэглэлийн бичиг” зэрэг ажлуудыг онцолж байна.

-Аяны хүрээнд : Төрийн албан хаагчдын дунд байгууллага бүр дотооддоо авлига, ёс зүйн чиглэлээр судалгаа авсан. Тухайлбал: ЗДТГ-т 2 асуумжаар 15 албан хаагчдаас судалгаа авахад эдгээр 15 албан хаагчийн 73 % нь байгууллагад ёс зүйн зөрчил байна. 40 % нь ашиг сонирхлын зөрчил байгаа гэж судалгаанд гарсан. Иймд судалгааны мөрөөр зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авна. Үр дүнд нь иргэд болон төрийн албан хаагчид цаг ямагт мэндлэх, хүндлэх ёсыг дээдэлдэг болсон.

Аянаар хийгдсэн Зөрчлийн талоныг үргэлжлүүлэн зохион байгуулж жилийн эцэст дотооддоо дүгнэх юм.

-Ардын хувьсгалын 100, 101, аймаг байгуулагдсны 80 жилийн ойг угтсан “ТОХИЛОГ ОРЧИН-ХӨГЖЛИЙН ЭХЛЭЛ” сэдэвт орчны тохижилтын ажлыг зохион байгуулахаар аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд 2022.06.22-2022.07.22 ны 2500000 (Хоёр сая таван зуун мянган) төгрөгийн шагналын сантай уралдаан зарлаад байна.

-Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр

а/. Аймгийн ХШҮ-ний хэлтэстэй хамтран “ХШҮ-ний бүсийн сургалт”-ыг (Эрдэнэцагаан, Асгат сум оролцсон) суманд 2022.06.24, 25 ны өдрүүдэд зохион байгууллаа.

б/. “Ёс зүйн харилцаа хандлага” сэдвээр ЗДТГ, Цэцэрлэг, ЕБС- БЦГХЗахиргаа, ЭМТ зэрэг байгууллагууд дотооддоо сургалтыг танхимаар зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд ЕБС нь “Зочин багш” урьж ирүүлэн сургалт хийсэн.

в/. Цэцэрлэг аймгийн мэргэжилтэнг урьж “Ёс зүйн” цахим сургалтыг хийсэн.

г/. “АМЬДРАЛ ТУУЛСАН АХМАДЫН ЗӨВЛӨМЖ” сэдэвт “Гэрээр зочлох” хэлбэрт сургалт сурталчилгааны ажлыг үргэлжлүүлэн сумын 1 дүгээр багт ажиллаж байна.

д/. Сумын 4 багийн Иргэдийн нийтийн хурлыг 2022.06.20 ноос эхлэн 4 хоногт багтаан зохион байгуулж ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авах, батлах, Цаг үеийн мэдээлэл хийж, хөдөө аж ахуй, нийгмийн даатгал, нийгмийн халамж, татварын чиглэлээр сурталчилгаа зохион байгуулж аймгийн “Нийтийн номын сан”- тай хамтран явуулын номын сан ажиллуулж, “ЯРУУ ҮДЭШ” дуу шүлгийн цэнгүүн зохион байгууллаа.

Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

1/. 2022 оны хагас жилийн хөдөө аж ахуйн болон мал тооллогын ажлыг зохион байгуулж 243 малчин өрхийг тооллогод 100 % хамруулаад байна.

2/. Зорилтот бүлгийн 10 өрхөд аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сумаас сонгогдсон 2 төлөөлөгчид 10 гэрийг гардуулж өгөв.

Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Тус сумын ЕБС-ийн 12 дугаар ангийн анхны 21 төгсөгчид сумын ЗДТГ-аас зохион байгуулсан “Байгальд ээлтэй шилдэг анги” уралдаанд амжилттай оролцож тэргүүн байрт шалгарсан бөгөөд төрөлх сургуульдаа үлдэцтэй бүтээн байгуулалтын ажлыг хийлээ.

Тус сумаас элсэлтийн ерөнхий шалгалтад 21 төгсөгчид маань оролцож байна.

Сургууль, Цэцэрлэгийн байгууллагууд гаднах, дотор орчноо тохижуулж мод, цэцгийн мандлаа сэргээж, анги танхимын урсгал засварын ажлыг хийж байна.

Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр

-Аймгийн ИТХ-ын сумаас сонгогдсон төлөөлөгчид сумын ЭМТ-д түргэн тусламжийн зориулалтаар приус-30 маркийн суудлын автомашиныг гардуулж өгсөн.

Зургаа: Байгаль орчны чиглэлээр.

-Сумын хэмжээнд нийт 4100 ширхэг модыг тариад байгаа. Үүнээс 15 сая төгрөгийн өртөгтэй 1000 ширхэг гоёлын модыг иргэд, төрийн байгууллагуудад хуваарилан өгч тарьж ургуулж байна.

-Мөн Ганга нуурт мод тарих ажлын БЦГХЗахиргаа хариуцан ажиллаж байгаа бөгөөд иргэдийн өөрсдийн санаачилгаар мод тарих ажил өрнүүлж байна.

“**Байгальд ээлтэй шилдэг анги**” уралдааныг сумын Засаг даргын нөөцөөс 1500000 (Нэг сая таван зуун мянган) , иргэд байгууллагуудын хандиваар 1300000 төгрөг нийт 2.8 сая төгрөгийн шагналын сантайгаар зохион байгуулж дүгнэлээ.

-Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2022 оны 03 дугаар сарын 4-ны өдрийн А/136 дугаар тушаалаар Эрдэм шинжилгээний хурлыг 2022.06.13-ны өдөр Хилийн 0184 дүгээр ангийн байранд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Хил хамгаалах байгууллагын харъяа хилийн анги, салбаруудын бие бүрэлдэхүүн, хил хамгаалах байгууллага, төрийн захиргааны болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн, эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны төв, их дээд сургуулиудын эрдэмтэд, судлаач, профессор, багш, практикийн ажилтнууд оролцсон.

Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргааны дарга “Хил хамгаалах байгууллагын улсын хил хамгаалалтын болон тусгай хамгаалалттай газрын байгаль орчныг хамгаалах эрх ашгийг уялдуудах харилцан ажиллах нь” сэдвээр илтгэл тавиж хамтран ажиллах санамж бичгийг баталгаажууллаа.

-Дэлхийн байгаль хамгаалах өдөр болон хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан жил бүр уламжлан зохион байгуулдаг гар зургийн уралдааныг 3-5 дугаар ангийн суралцагчдын дунд **«Миний хайртай амьтан»** сэдвээр зохион байгууллаа. Дээрхи уралдаанд нийт 18 хүүхэд оролцож 3 хүүхдийг шалгаруулан шагнаж урамшуулав

- Дарьгангын Байгалийн Цогцолборт газарт “Монгол тарваганы тархац, тоо толгой, нягтшилын судалгаа”-ны ажлыг 2022 оны 5 сарын 8-ны өдрөөс эхлэн 7 дугаар сарын 05-ны өдөр, 09 дүгээр сарын 15-23-ныг хүртэлх хугацаатай хийхээр ШУА-ийн

Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, Монголын Ирвэс хамгаалах төвийн гүйцэтгэх захирал доктор, дэд профессор Б. Мөнхцогтой гэрээ байгуулан судалгааны ажлыг эхлүүлээд байна.

-Аймгийн Байгаль орчны газартай хамтран тус сумын нутагт (Нартын уул) 30 тарвага нутагшуулан байршуулах ажил хийгдэж байна.

-Багийн иргэдийн нийтийн хурлаас иргэдийн 100 % ийн саналаар Сумын төвийн “НЭГСЭН ХОГ” -ийн цэгийг булшлах саналыг дэмжсэн бөгөөд одоогоор нэгдсэн хогийн цэгийг ковшоор дотогш түрэх, цэгцлэх ажлыг хийж байна.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР